

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
2026 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ТАЙЛАН**

2026.06.18

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

“Дархан-Уул аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн үр дүнг шударга үнэлэх, гарсан дүгнэлт зөвлөмжийг тусгах, хариуцлагыг сайжруулах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, зорилт, арга хэмжээг бүрэн биелүүлэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үндэслэл, арга зүй

Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын дагуу “Дархан-Уул аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн тайланд үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ.

“Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын 2.4-д заасан дагуу Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн тайланг урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн зорилт арга хэмжээ тус бүрээр аргачлалын дагуу хувиар илэрхийлж дүгнэсэн.

Дархан-Уул аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн тайланг энэхүү журмын 2.5-д заасны дагуу арга хэмжээний үнэлгээг 3 ангилалд шилжүүлэн тооцсон.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээ

Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилт нийт 4 зорилтын 26 арга хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд:

Төвийн 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт

Зорилт	Арга хэмжээний тоо	Хэрэгжилт хувиар / % /			Хэрэгжих хугацаа болоогүй
		85 буюу түүнээс дээш хувь	70-85 хүртэл хувь	70 хүртэл хувь	
Нэг.Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт	3	2	-	-	1
Хоёр.Нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилт	13	13	-	-	-
Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ	6	4	-	1	1
Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах арга хэмжээний хэрэгжилт	4	3	-	-	1

Нийт 4 зорилт	26	22	-	1	3
---------------	----	----	---	---	---

1. Бүрэн хангалттай" 22 арга хэмжээ
2. Хангалтгүй" 1 арга хэмжээ
3. Төлөвлөгөөнд тусгагдсан хугацаа болоогүй 3 арга хэмжээ байна.

Дархан-Уул аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтийн ерөнхий дүнгээр **95.6 хувь** буюу **"бүрэн хангалттай"** үнэлэгдлээ.

Төлөвлөгөөний хэрэгжилт 70%-иас бага хангалтгүй үнэлэгдсэн арга хэмжээг танилцуулбал:

**2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 70%-иас
бага үнэлэгдсэн арга хэмжээ**

№	Стратеги төлөвлөгөө	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1	Цаг агаарын урьдчилсан мэдээний таарц, чанар	-	Мэдээний тоо хувь	Мэдээний таарц 99.0 %	Мэдээний таарц 99.1%	1. Нарийвчилсан мэдээний таарц 97.3% 2. Хоногийн мэдээний таарц 93.4% 3. 5 хоногийн мэдээний таарц 87.0% 4. Цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс сэрэмжлүүлэх 11 мэдээний илүүлэлт, онч, таарц 100% Нэгдсэн дүнгээр 98.9%-тай дүгнэгдэж зорилтот түвшингөөс -0.2% -иар буурсан.	0%

Цаг агаарын 4 төрлийн урьдчилсан мэдээний таарцын нэгдсэн дүнгээр 98.9%-тай дүгнэгдэж зорилтот түвшингөөс 0.2% -иар буурсан тул сүүлийн хагас жилд мэдээний таарцыг сайжруулж зорилтот түвшинд хүргэж ажиллаах шаардлагатай байна.

Төвийн албан хаагчдын ажллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2026 оны төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтийг журмын 2.5-д заасан аргачлалын дагуу үнэлэхэд 96.0% буюу **"бүрэн хангалттай"** үнэлэгдлээ.

**2026 оны төвийн албан хаагчдын ажллах нөхцөл,
нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний
хэрэгжилт**

Зорилт	Арга хэмжээний тоо	Хэрэгжилт хувиар / % /			Хэрэгжих хугацаа болоогүй
		85 буюу түүнээс дээш хувь	70-85 хүртэл хувь	70 хүртэл хувь	
Нэг. Албан хаагчдын ажлын байрны орчин, нөхцөлийг сайжруулах	4	3	-	-	1

Хоёр.Цалин хөлс, нэмэгдэл, шагнал урамшуулал, тэтгэвэр тэтгэмж, нөхөн төлбөр, тусламж дэмжлэгийг хуулийн хүрээнд үзүүлэх	6	6	-	-	-
Гурав.Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалж, эрүүл амьдрах дадлыг хэвшүүлэх	6	5	1	-	-
Дөрөв.Албан хаагчдын ажил амьдралын тэнцвэрт байдлыг хангах	2	2	-	-	-
Тав.Төрийн албан хаагчийн нийгмийн хэрэгцээ, сэтгэл зүйн хандлагыг мэдэрч байгууллагын соёл, уур амьсгалыг өөрчлөх замаар албан хаагчдын ажлын байран дахь сэтгэл ханамжийг дээшлүүлэх	4	3	-	-	1
Зургаа. Албан хаагчдын сурч хөгжих боломжийг бүрдүүлж, дэмжлэг үзүүлэх	6	6	-	-	-
Нийт 6 зорилт	28	25	1	-	2

2026 оны төвийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэхэд бүрэн хангалттай 25 арга хэмжээ, хангалттай 1 арга хэмжээ, хугацаа болоогүй 2 арга хэмжээ байгаа бөгөөд ерөнхий дүнгээр **96.0 хувь** буюу **"бүрэн хангалттай"** үнэлэгдлээ.

Төлөвлөгөөний хэрэгжилт 70-85%-иар үнэлэгдсэн нэг арга хэмжээ нь хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилладаг албан хаагчдад олгох хор саармагжуулах бүтээгдэхүүний зардал 2026 оны төсвийн 12 дугаар сар дээр тавигдсан учир 2025 оны үйл ажиллагааны давсан орлогоос 70%-ийг шийдвэрлэсэн байна.

"Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам"-ын дагуу www.shilen.gov.mn цахим мэдээллийн сайтад 5 төрлийн 20 мэдээлэл байршуулж 2026 оны 1 дүгээр улиралд 86.2%-тай дүгнэгдсэн бөгөөд 2 дугаар улиралд үнэлгээг 90%-д хүргэнэ.

УЦУОШТөвийн үйл ажиллагаанд 5 дугаар сараас Төрийн үйлчилгээний хүсэлтийн бүртгэл хяналтын системийг нэвтрүүлж иргэнийг <https://service.e-mongolia.mn>, ААНБ-ыг <https://les.e-business.mn/> хүсэлтийг системээр хүлээн авч ажлын 1-5 хоногийн дотор цаг агаарын тодорхойлолт гаргаж үйлчилж байна.

4 дүгээр сараас Байгаль орчны шинжилгээний сорьц бүртгэл, хяналтын <https://dlab.weather.gov.mn> систем нэвтэрч иргэн, ААНБ-уудын шинжилгээ хийлгэх хүсэлтийг хүлээн авч хариуг цахимаар илгээж байна.

Шадар сайдын "Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийх" нэгдсэн удирдамжийн дагуу тус төвөөс аймгийн хэмжээний 2026 оны хур борооны үерийн эрсдэлийн үнэлгээ хийсэн. Эрсдэл 4.2 буюу **"дунд эрсдэлтэй"** үнэлэгдэж эрсдлийг бууруулах дүгнэлт, зөвлөмж, санал боловсруулж тайланг баталгаажуулан аймгийн Онцгой комисс, Онцгой байдлыг газарт 2026 оны 6 дугаар сарын 08-нд хүргүүлсэн.

2026 оны эхний хагас жилийн байдлаар байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гомдол, санал ирээгүй.

Дөрөв. Дүгнэлт

1. Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилт 95.6%-тай үнэлэгдсэн.

2. 2026 оны төвийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилт 96.0%-тай үнэлэгдсэн.

3. Эхний хагас жилд цахим үйлчилгээ үйлчилгээ нэвтэрүүлж эхэлсэн байна. Төрийн үйлчилгээний хүсэлтийн бүртгэл хяналтын системийг нэвтрүүлж иргэний хүсэлтийг <https://service.e-mongolia.mn>, ААНБ-ын хүсэлтийг <https://les.e-business.mn/> платформоор хүлээн авч ажлын 1-5 хоногийн дотор цаг агаарын тодорхойлолт гаргаж үйлчилж байна. Мөн <https://dlab.weather.gov.mn> систем нэвтэрч иргэн, ААНБ-уудын байгаль орчны шинжилгээ хийлгэх хүсэлтийг хүлээн авч хариуг цахимаар илгээж төрийн үйлчилгээг түргэн шуурхай үйлчилгээ үзүүлж эхэлсэн.

4. Байгууллагын 2026 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу 6 төрлийн сургалт хийгдэж давхардсан тоогоор 111 албан хаагч оролцсон. Гадаад хамтын ажиллагааны хүрээнд БНСУ, БНХАУ-д 7-14 хоногийн сургалтад 3 албан хаагч хамрагдсан нь байгууллагын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, мэргэжлийн ур чадварыг сайжруулах зорилт биелэгдэж байна.

5. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд арга хэмжээний суурь түвшин, шалгуур үзүүлэлтийг тодорхой тусгасан, хүрсэн түвшинг, хүрэх түвшинтэй уялдуулан тайлагнах тухай 2025 оны зөвлөмжийг хэрэгжүүлсэн.

Тав. Зөвлөмж

1. Тухайн төлөвлөсөн арга хэмжээ хэрэгжихгүй байх эрсдэлийг урьдчилан тооцоолох, хариу арга хэмжээг шуурхай авч ажиллах, хэрэгжээгүй тохиолдолд шалтгаан нөхцлийг тодорхой тайлагнаж холбогдох нотлох баримтыг хавсаргах

2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, төвийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөнд хугацаа болоогүй 5 ажлыг сүүлийн хагас жилд бүрэн хэрэгжүүлэх

3. Мөн дээр 2 төлөвлөгөөний хэрэгжилт 70%-иас бага үнэлэгдсэн цаг агаарын урьдчилсан мэдээний таарцыг сайжруулах, 70%-иар үнэлэгдсэн хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилладаг албан хаагчдад олгох хор саармагжуулах бүтээгдэхүүний зардалыг бүрэн шийдэх

4. www.shilen.gov.mn цахим мэдээллийн сайтад 5 төрлийн 20 мэдээлэл байршуулж үнэлгээгээ ахиулах

5. Дараагийн тайланд зөвлөмжийг хэрэгжүүлж тайлагнах зэрэг зөвлөмж өгч байна.

ТАНИЛЦСАН:

УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
ДАРГА



С.АЛТАНДОЛГИОН

ТАЙЛАГНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ

ГИШҮҮН

Б. Дариймаа

Л.ГҮНЖИДМАА

Б.ДАРИЙМАА